

БАТЛАВ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
Х.БАТБИЛЭГ

2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНД  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**


**Зорилго:** Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн Батлан хамгаалах салбарын алба хаагчдад ойр, уян хатан, идэвхтэй, санаачилгатай бөгөөд цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн манлайлагч чадварлаг алба хаагдыг бэлтгэх, батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого, зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр төвшинд хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гадаад, дотоодын цэргийн академи, их, дээд сургуулиудад офицер, ахлагч, сонсогч, оюутнуудыг суралцуулах, мэргэшүүлэх, мэргэжил олгох, шагнаж урамшуулах, нийгмийн хамгааллын баталгааг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн маргааныг хянан шийдвэрлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахад оршино.

д/д	Хийгдэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Гүйцэтгэлтийн шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1.	Батлан хамгаалах яамны харьяа байгууллагад Төрийн албаны тухай хууль тогтоомж болон Төрийн албаны зөвлөлийн өгсөн үүргийн биелэлтийг зохион байгуулах	Жилдээ	Салбар зөвлөлийн ажлын албаны дарга, нарийн бичгийн дарга	Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол, дүрэм, журамд нийцсэн байна.	Төрийн албаны тухай хууль хэрэгжиж, Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, шаардлагатай мэдээллээр хангасан байна.
2.	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх	Жилдээ	Салбар зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга	Төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, холбогдох хууль, дүрэм, журмын шаардлагыг хангасан байх.	Батлан хамгаалах салбарын удирдах албан тушаалын сул орон тоог нөхөн хангах асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийг зөв сонгож байршуулсан байна.


3.	Төрийн албаны зөвлөлд төрийн алба, төрийн албан хаагчидтай холбоотой мэдээ, тайлан, судалгааг Төрийн албаны зөвлөлөөс гаргасан графикын дагуу гаргаж хүргүүлэх	Жилдээ	Салбар зөвлөлийн ажлын албаны дарга, нарийн бичгийн дарга	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолын дагуу цаг хугацаанд нь хүргүүлсэн байх.	Төрийн албаны зөвлөлд хүргүүлдэг мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлж хэвшсэн байна.
4.	Төсвийн байгууллагуудад төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах	Жилдээ	Салбар зөвлөл	Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журамд нийцсэн байна.	Ажлын үр дүн сайжирч, мэргэшсэн боловсон хүчинтэй болж, алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудал сайжирсан байна.
5.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн болон өргөдөл, гомдол маргааны мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Жилдээ	Салбар зөвлөлийн ажлын албаны дарга, нарийн бичгийн дарга	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол шийдвэрлэх тухай хуульд нийцсэн байна.	Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/90 дугаар тушаалаар батлагдсан "Батлан хамгаалах яаманд цэргийн алба хаагч, бэлтгэл болон чөлөөнд гарсан офицер, ахлагч, ажилтан, албан хаагчид, иргэдээс хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу хугацаанд нь шийдвэрлэж хэвшсэн байна.
6.	Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлэн томилогдсон Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбогдож гарсан маргааныг хянан шийдвэрлэх	Жилдээ	Салбар зөвлөл	Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хянан шийдвэрлэсэн байна.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбогдож гарсан маргааныг хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргасан байх
7.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хурлын материаллаг баазыг сайжруулах	Жилдээ	Салбар зөвлөлийн ажлын албаны дарга, нарийн бичгийн дарга		Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоол "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын дагуу салбар зөвлөлийн үйл

					ажиллагааны жилийн төсвийн төслийг боловсруулж хэвшсэн, ажиллах нөхцөл бололцоогоор хангагдсан байна.
--	--	--	--	--	---

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
ХУРАНДАА  Ө.ЭРДЭНЭ-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН,  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
АХМАД  Д.ҮҮРЦАЙХ